



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 4/188

Улаанбаатар хот

Улаанбурхан, улаанууд өвчний эсрэг
вакцинаар нэмэлт дархлаажуулалт
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.24, 35 дугаар зүйлийн 35.6 дэх хэсэг, Дархлаажуулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Сайдын зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 2 дугаар хурлын шийдвэр, Дархлаажуулалтын үндэсний зөвлөх хорооны 2023 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Улсын хэмжээнд 10 сараас 8 насны хүүхдийг Улаанбурхан, улаанууд өвчний эсрэг вакцинаар 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн нэмэлтээр дархлаажуулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Ж.Байгалмаа), Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

2. Улаанбурхан, улаанууд өвчний эсрэг хавсарсан вакциныг хэрэглэх зааврыг нэгдүгээр, Улаанбурхан, улаанууд өвчний эсрэг вакцин, зүү, тариур, аюулгүй хайрцгийн хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Нэмэлт дархлаажуулалтын ач холбогдолын талаар батлагдсан төлөвлөгөөний дагуу хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (С.Өнөрсайхан), Халдварт өвчин судлалын үндэсний төв (Ж.Байгалмаа), Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, захирал нарт даалгасугай.

4. Дархлаажуулалтын үйл ажиллагаа, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар (С.Сүнчин) -т тус тус даалгасугай.

САЙД



С.ЧИНЗОРИГ

141223834

Эрүүл мэндийн сайдын 2023 оны 5
дугаар сарын 26-ны өдрийн 118 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

Улаанбурхан, улаанууд өвчний эсрэг хавсарсан вакциныг хэрэглэх заавар

Найрлага:

Улаанбурхан, улаанууд өвчний эсрэг хавсарсан вакциныг (Эдмонстон Загреб) улаанбурхан, (Вистар РА 27/3) улаануудын амьд вирусээс гарган авсан. Улаанбурхан, улаануудын вирусийг хүний диплоид эс дотор үржүүлсэн. Вакцин нь хөлдөөж хатаасан хуурай, тусгай уусгагч шингэнтэй, цайвар шаргал өнгө бүхий бодис юм. Вакцин нь ДЭМБ-ын шаардлагыг TRS 840 (1994) аргачлалын дагуу хангасан.

Хамгаалах чадвар:

0,5 мл буюу 1 хүн тун нь улаанбурханы вирусийг 1000 CCID₅₀-иас цөөнгүй, улаануудын вирусийг 1000 CCID₅₀ хэмжээгээр тус тус агуулсан.

Хэрэглэх заавар:

Улаанбурхан, улаанууд өвчний эсрэг идэвхитэй дархлаа тогтоох зорилгоор нярай, хүүхэд, өсвөр насныхан, залуучуудад хэрэглэнэ. Вакциныг сахуу татран хөхүүл ханиад, сахуу татран, сүрьеэ, халдварт саа, хемофилюс инфлюэнза В хэв шинж, В гепатит, шар чичрэгийн эсрэг вакцин, А аминдэмтэй цуг хэрэглэж болно.

Товлолт болон нөхөн дархлаажуулалтад хамрагдсан эсэхээс үл хамааран нэмэлт дархлаажуулалтад хамруулах бөгөөд хэрэв хүүхэд сүүлийн 1 сарын дотор аль нэг вакцин, иммуноглобулинд хамрагдсан бол улаанбурхан, улаануудын эсрэг вакцин хийхийг түр хойшлуулан сарын дараа нэмэлт дархлаажуулалтад хамруулах.

Тун хэмжээ:

Вакциныг тарихдаа нэг удаагийн ариун зүү, тариур хэрэглэх бөгөөд зөвхөн вакциныг дагалдаж ирсэн уусгагчаар найруулна. Уусгагчийг хийж зөөлөн сэгсрэхэд нунтаг бодис хялбар уусна. Вакциныг найруулсан даруйдаа 0,5 мл-ээр соруулан авч, бугалганы дээд хэсгийн арьсан дор тарина. Задалсан вакциныг тэр даруйд нь хэрэглээгүй тохиолдолд +2-+8 хэмийн харанхуй орчинд 6 цагаас илүүгүй хадгална. 6 цагийн дараа задалсан вакциныг устгана.

Вакциныг өөр үйлдвэрлэгчийн улаанбурхан-улаануудын эсрэг вакцины найруулах уусмал болон тарилгын шингэнээр найруулж болохгүй. Өөр уусгагчаар найруулснаас вакцины чанарт нөлөөлөх, хүнд урвал илэрч болзошгүй. Уусгагч шингэнийг хөлдөөж болохгүй. Уусгагч шингэн болон найруулсан вакцинд гадны биет хөвсөн, бохирдсон байвал устгана.

Дархлаажуулалтын дараах урвалууд хөнгөн явагддаг. Вакцин хийлгэсний дараа 24 цагийн дотор тарьсан газар улайх, бага зэрэг эмзэглэлтэй байж болно. Дээрх шинж тэмдэгүүд ихэвчлэн 2-3 хоногийн дараа ямар нэг эмчилгээгүй арилна. Вакцин хийлгэсэн хүмүүсийн 5-15%-д нь 7-12 хоногийн дараа хөнгөн халууралт ажиглагдаж 1-2 өдрийн дараа арилна. Вакцин хийлгэснээс 7-10 хоногийн дараа ойролцоогоор 2%-д хөнгөн тууралт ажиглагдаж, 2 хоног үргэлжлэнэ. Улаанбурханы

эсрэг вакцины 1 сая хүн тун тутамд 1 энцефалит бүртгэгдэх боломжтой боловч вакцинтай хамааралтай болох нь батлагдаагүй. Бага зэргийн халууралт, тууралт, лимфаденопати, булчингийн өвдөлт, парастесиа ихэвчлэн бүртгэгддэг. Тромбоцитопения ховор тохиолдох бөгөөд 30 000 тун тарихад нэгээс бага тохиолдол бүртгэгдсэн байна. Анафилактик шок ховор тохиолдолд бүртгэгдэнэ.

Вакцин хийлгэснээс хойш 2 долоо хоногийн дотор иммуноглобулиныг хийлгэж болохгүй.

Улаанбурхан, улаанууд өвчний эсрэг нэмэлт дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчдад дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлтэй холбоотой зөвлөмж мэдээллийг заавал өгнө.

Эсрэг заалт, анхааруулга:

Уг вакциныг дараах тохиолдолд хэрэглэхгүй. Үүнд:

- Кортикостеройд, бусад төрлийн дархлаа дарангуйлах эм, туяа эмчилгээний үед, стеройдын өндөр тунгаар эмчилгээ хийлгэж байгаа тохиолдолд,
- Халуурсан, цочмог халдварт өвчин, жирэмсэн, лейкеми, лимфома, хурц цус багадалт, цусны тогтолцооны бусад цочмог өвчин, бөөрний үйл ажиллагааны хурц дутагдлын үед,
- Декомпенсацийн шатанд буй зүрхний өвчний үед,
- Иммуноглобулин хийлгэсэн эсвэл цус сэлбүүлсэн тохиолдолд,
- Вакцины найрлагад орсон бодист харшилтай хүнд,
- Неомицин болон өндгөнд харшилтай хүнд,
- Неомицин хийлгэсний дараа.

Харин бага зэргийн халуунтай, хөнгөн хэлбэрийн амьсгалын замын болон суулгалттай, хоол тэжээлийн дутагдалтай хүүхдүүд эсрэг заалтанд орохгүй.

Хадгалах нөхцөл, хугацаа:

Вакциныг гэрлээс хамгаалж +2-+8 хэмд харанхуй газар хадгална. Уусгагч шингэнийг хөлдөөж болохгүй, сэрүүн нөхцөлд хадгална.

Вакцин шошгоны заагуур болон вакцины флакон дээрх дуусах хугацааг харж хэрэглэнэ.

Вакциныг үйлдвэрлэсэн: Энэтхэг улсын “Серум Институт” вакцины үйлдвэр.

Эрүүл мэндийн сайдын 2023 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн /16/ дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Улаанбурхан, улаанууд өвчний эсрэг хавсарсан вакцин, зүү тариур, аюулгүй хайрцгийн хуваарь

Д/д	Аймаг, дүүрэг	Хамрагдвал зохих хүний тоо										Нийт хамрагдвал зохих хүний тоо	Олгох вакцин /хүн тун/	Өөрөө эвдэрдэг тариур /ширхэг/	Найруулдаг тариур /ширхэг/	Аюулгүй хайрцаг /ширхэг/
		10-11 сар	1 нас	2 нас	3 нас	4 нас	5 нас	6 нас	7 нас	8 нас						
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	
1	Архангай	526	2,131	2,079	2,054	2,099	2,129	2,172	2,166	2,201	17,557	15,670	15,670	1,567	172	
2	Баян-Өлгий	755	2,978	3,002	2,845	2,803	2,712	2,627	2,665	2,594	22,981	20,500	20,500	2,050	226	
3	Баянхонгор	521	2,204	2,256	2,150	2,021	1,954	2,014	2,095	2,233	17,448	15,570	15,570	1,557	171	
4	Булган	327	1,242	1,254	1,269	1,271	1,198	1,359	1,378	1,327	10,625	9,480	9,480	948	104	
5	Говь-Алтай	339	1,469	1,343	1,259	1,188	1,099	1,200	1,169	1,242	10,308	9,200	9,200	920	101	
6	Говьсүмбэр	113	437	441	481	416	457	457	497	503	3,802	3,400	3,400	340	37	
7	Дархан-Уул	558	2,304	2,407	2,409	2,246	2,386	2,432	2,522	2,347	19,611	17,500	17,500	1,750	193	
8	Дорноговь	397	1,612	1,551	1,593	1,520	1,601	1,734	1,674	1,662	13,344	12,000	12,000	1,200	132	
9	Дорнод	461	2,087	2,028	2,039	2,003	2,066	1,938	1,976	1,913	16,511	14,750	14,750	1,475	162	
10	Дундговь	283	1,144	1,154	1,123	1,024	1,042	1,042	965	949	8,726	7,800	7,800	780	86	
11	Завхан	383	1,615	1,617	1,600	1,467	1,473	1,630	1,605	1,534	12,924	11,600	11,600	1,160	128	
12	Орхон	563	2,340	2,402	2,448	2,318	2,485	2,388	2,389	2,467	19,653	17,600	17,600	1,760	194	
13	Өвөрхангай	622	2,763	2,754	2,545	2,485	2,653	2,698	2,669	2,675	21,864	20,000	20,000	2,000	220	
14	Өмнөговь	444	1,951	1,896	1,849	1,563	1,683	1,792	1,732	1,785	14,695	13,200	13,200	1,320	145	
15	Сүхбаатар	398	1,663	1,604	1,528	1,501	1,448	1,558	1,506	1,425	12,631	11,300	11,300	1,130	124	
16	Сэлэнгэ	545	2,352	2,469	2,318	2,177	2,247	2,340	2,427	2,303	19,178	17,500	17,500	1,750	193	
17	Төв	486	2,081	2,058	2,086	2,049	2,067	2,175	2,136	2,098	17,236	15,400	15,400	1,540	169	
18	Увс	509	2,157	2,047	1,993	2,055	2,024	1,981	2,029	1,911	16,706	15,000	15,000	1,500	165	
19	Ховд	546	2,317	2,242	2,285	2,103	2,106	2,124	2,113	2,206	18,042	16,100	16,100	1,610	177	

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16
20	Хөвсгөл	729	2,989	3,033	3,023	2,854	3,000	3,034	3,244	3,192	25,098	22,390	22,390	2,239	246
21	Хэнтий	440	1,889	1,828	1,746	1,708	1,837	1,807	1,788	1,800	14,843	13,240	13,240	1,324	146
	Аймгийн дүн	9,942	41,725	41,465	40,643	38,871	39,520	40,502	40,745	40,367	333,780	299,200	299,200	29,920	3,291
1	Багануур	150	601	634	650	552	598	637	689	721	5,232	1,700	1,700	170	19
2	Багахангай	28	101	105	108	114	97	82	111	107	853	800	800	80	9
3	Баянгол	1 249	5,161	5,500	5,509	5,439	5,946	6,156	6,471	5,980	47,411	42,300	42,300	4,230	465
4	Баянзүрх	2 093	8,254	8,980	9,127	8,916	9,626	9,778	9,764	9,789	76,327	68,500	68,500	6,850	754
5	Налайх	219	874	867	862	813	845	967	972	968	7,387	6,600	6,600	660	73
6	Сонгинохайрхан	1 826	7,765	8,135	8,158	7,730	8,688	8,864	8,696	8,488	68,350	61,000	61,000	6,100	671
7	Сүхбаатар	696	2,930	3,052	3,192	3,069	3,246	3,382	3,572	3,505	26,644	23,800	23,800	2,380	262
8	Хан-Уул	1 203	4,974	5,109	5,257	5,254	5,770	5,839	5,924	5,655	44,985	40,600	40,600	4,060	447
9	Чингэлтэй	781	3,312	3,336	3,345	3,238	3,417	3,551	3,660	3,575	28,215	25,500	25,500	2,550	281
	Дүүргийн дүн	8,244	33,972	35,718	36,208	35,125	38,233	39,256	39,859	38,788	305,403	270,800	270,800	27,080	2,979
	Нийт дүн	18,186	75,697	77,183	76,851	73,996	77,753	79,758	80,604	79,155	639,183	570,000	570,000	57,000	6,270